

”МонФрэш Шүүс” ХХК-ийн нийтэд санал
болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “МонФрэш Шүүс” ХХК нь хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсантай холбогдуулан уг компанийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 148 320 348 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, Хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “МонФрэш Шүүс” ХХК-ийн хувьцааны 51 хувийг эзэмшигч иргэн Т.Насанхүүгийн эзэмшилд байгаа хаалттай компанийн хувьцаа нээлттэй ХК-ийн 52.693.378 ширхэг, 40 хувийг эзэмшигч “Донгфа Шинда” компанийн эзэмшилд байгаа хаалттай компанийн хувьцаа нээлттэй ХК-ийн 41.328.139 ширхэг, 9 хувийг эзэмшигч иргэн Б.Алтангэрэлийн эзэмшилд байгаа хаалттай компанийн хувьцаа нээлттэй ХК-ийн 9.298.831 ширхэг хувьцаа болон тус тус хөрвөсөн тул өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д зөвшөөрсүгэй.

3. “МонФрэш Шүүс” ХХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 45.000.000 ширхэг хувьцааг нийтэд санал болгон Хөрөнгийн биржээр арилжаалахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 2-т заасан нэр бүхий иргэдийн өмчлөлд бүртгэсэн хувьцааг анхдагч зах зээлийн арилжаа дууссан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тусгаарлаж хоёрдогч зах зээлийн арилжаанд оруулахгүй байхыг “Үнэт цаас, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

5. Үнэт цаас гаргах үйл ажиллагааны талаар олон нийтэд хандсан сурталчилгааг хангалттай сайн хийх, улмаар энэ тогтоолын 3-т заасан нийтэд санал болгон арилжаалах 45.000.000 ширхэг хувьцааны анхдагч зэх зээлийн арилжааг Хорооноос авсан зөвшөөрлийн үндсэн дээр эхлүүлэхийг “МонФрэш Шүүс” ХХК /Т.Насанхүү/, брокер, дилер, андеррайтерийн “Монголын олон улсын

хөрөнгийн корпораци” ХХК (Д.Ачит-Эрдэнэ), “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

6. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа зохих журмын дагуу явагдаж дууссаны дараа тус Хорооноос зөвшөөрөл олгох хүртэл хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг

2

нээхгүй байх, хоёрдахь зах зээлтэй холбогдох гүйлгээг гүйцэтгэхгүй байхыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

7. “МонФрэш Шүүс” ХХК нь хэлбэрээ өөрчлөн ХК болж буйгаа Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэхийг “МонФрэш Шүүс” ХХК /Т.Насанхүү/-д даалгасугай.

8. Хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан дотоод журмуудыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг “МонФрэш Шүүс” компани /Т.Насанхүү/-д үүрэг болгосугай.

9. Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасыг зохих журмын дагуу олон нийтэд сурталчилж, бодитой мэдээллээр хангаж, үнэт цаасны арилжааны тайланг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг зохих журмын дагуу хангаж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “МонФрэш Шүүс” компани /Т.Насанхүү/, брокер, дилер, андеррайтерийн “Монголын олон улсын хөрөнгийн корпораци” ХХК (Д.Ачит-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.

10. Энэ тогтоолын хэрэгжилтэд биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ